



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМЛИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН **Б.БАЯРТУЯА**

АВИЛГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 02 сарын 14

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр							
1.1 Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах хариуцлагыг дээшлүүлэх	1.	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын шинэчилсэн мэдүүлгийг бүртгэж баталгаажуулна.	Жилдээ			Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын ХАСУМ болон ХО-ын шинэчилсэн мэдүүлгийг хугацаанд гаргуулж хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Эрх бүхий албан тушаалтан
	2.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод нээлттэй болгоно.	Жилдээ			Шинээр томилогдсон албан тушаалтны нэр дэвшүүлсэн АТГ-ын дүгнэлтийг олон нийтэд нээлттэй мэдээлсэн байх.	
1.2 Нийтийн албанд томилогдох албан	3.	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол,	Жилдээ			Шинээр албан	Газрын дарга

тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх		туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилох.				тушаалд томилохдоо хуулийн дагуу дэвшүүлэн томилох зарчмыг баримтална.	
1.3 Авлигын эрсдлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх	5.	Авлигын эрсдлийн үнэлгээ хийж эрсдлээс хамгаалах арга хэмжээ авна.	Жилдээ			Авлигын эрсдлийг бууруулах арга хэмжээ авсан байх.	Эрх бүхий албан тушаалтан болон Ёс зүйн зөвлөл
1.4 Ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх	6.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.	Жилдээ			Зөрчлийг хэлтсийн ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргасан байна.	Ёс зүйн зөвлөл
1.5 Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	7.	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.	Жилдээ			Өргөдөл гомдол мэдээллийг хянан шалгаж, ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэх.	Ёс зүйн зөвлөл
1.6 Нийтийн албан	8.	Албан хаагчдад зориулсан	Жилдээ			Албан хаагчдын	Эрх бүхий

тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх		авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулна.				авилгын эсрэг мэдлэг, мэдээлэл сайжирсан байна.	албан тушаалтан
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр							
2.1 Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай баримт материалыг тоон хэлбэрт шилжүүлэн цахим мэдээллийн нэгдсэн сан / цахим архив/-ыг үүсгэнэ	9.	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг цахимаар хүлээн авна.	Жилдээ			Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж, цаг хугацаа хэмнэсэн байна.	Хамралт, орлого, цахим үйлчилгээ хариуцсан бацаагч
	10.	Нийгмийн даатгалын дэвтрийн цахим баталгаажуулалтыг хийх.	Жилдээ			Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж, цаг хугацаа хэмнэсэн байна.	
2.2 Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх	11.	Иргэдээс байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар үр дүнг сайжруулна.	Жилдээ			Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулна.	Хүний нөөцийн мэргэжилтэн, холбогдох албан тушаалтнууд
	12.	Иргэдээс байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг дотоод удирдлагын нэгдсэн UB ERP симтемийн өргөдөл гомдлын цэсэнд бүртгэж шийдвэрлэлтэнд хяналт тавих	Жилдээ			Өргөдөл гомдлыг дотоод удирдлагын нэгдсэн UB ERP симтемийн өргөдөл гомдлын цэсэнд бүртгэсэн байна.	Хүний нөөцийн мэргэжилтэн, холбогдох албан тушаалтнууд
	13.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль зүйн				Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд	

		үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишгийг тогтоолгоход анхаарч ажиллана.	Жилдээ			тавих хяналтыг сайжруулж хугацаа хэтрүүлэхгүй байх.	
Гурав. Төсөв санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр							
3.1 Төсөв санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах хариуцлагыг дээшлүүлэх	14.	Нийгмийн даатгалын сангийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл зарцуулалтын хариуцлагыг дээшлүүлэх	Жилдээ			Төсвийн хөрөнгө үр ашигтай зориулалтын дагуу зарцуулагдсан байна.	Ахлах нягтлан бодогч
	15.	Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг хуулийн хугацаанд албан ёсны цахим хуудсанд байршуулж, олон нийт танилцах боломоор хангах.	Жилдээ			Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэсэн байна.	Ахлах нягтлан бодогч, Хүний нөөцийн мэргэжилтэн
3.2 Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	16.	Байгууллагын 2024 оны төсвийн төсөлд байгууллагын албан хаагчдаас саналыг авч тусгах ажлыг зохион байгуулах	2 дугаар улиралд			Төсвийг албан хаагчдаас санал авч хэлэлцүүлж саналыг тусгасан байна.	Холбогдох албан тушаалтнууд
3.3 Нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох	17.	Байгууллагад дотоод аудит, хяналт шалгалтыг хийх, дүгнэлт, зөвлөмж өгнө.	Жилдээ			Байгууллагад дотоод аудит, хяналт шалгалт хийгдсэн байна.	Хяналт, шалгалтын байцаагч
Дөрөв. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:							

4.1 Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	18.	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор Авилгатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт тохируулан иргэдэд сурталчлах	Жилдээ			Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнг тооцож тайлагнасан байх	Эрх бүхий албан тушаалтан
4.2 Авилгын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулсан сургалтанд хамруулах	19.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн бололцоонд түшиглэн хүүхэд, залууст хүргэж, үр дүнг тооцож тайлагнасан байх	Жилдээ			Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх, хамрагдсан хүүхэд залуус иргэдийн тоогоор	Эрх бүхий албан тушаалтан
4.3 Авилгатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх.	20	АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	Жилдээ			Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайлбар хүргүүлсэн байх.	Эрх бүхий албан тушаалтан
4.4 Албан хаагчид авилгатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.	21	Авилгын эсрэг төрийн болон ТББ, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх.	Жилдээ			Гаргасан санал санаачилгыг дэмжиж ажилласан байх.	Албан хаагчид

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН



Б.УДВАЛ